

Гарчиг	
1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.2. Төслийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл.....	3
1.3. Уурхайн хүчин чадал.....	4
1.4. Уурхайн ажиллах горим	4
1.5. Уурхайн одоогийн байдал	5
1.6. Олборлолтын технологи.....	6
1.7. Уурхайн дотоод тээвэр	6
1.8. Уурхайн дэд бүтэц, түүхий эд.....	6
2. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	9
3. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....	12
4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	13
5. `НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	17
6. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	17
7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	18
8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	18
9. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	18
10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	21
12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	23
13. БОМТ-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	24



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн талбайн координат цэг.....	3
Хүснэгт 2. Олборлолтын хүчин чадал.....	4
Хүснэгт 3. Ил уурхайн хөрс хуулалтын хүчин чадал.....	4
Хүснэгт 4. Ил уурхайн хөрс хуулалтын итгэлцүүр (Ашиглалтын жил бүрээр).....	4
Хүснэгт 5. Howo 25 автосамосвалын техникийн үзүүлэлт.....	6
Хүснэгт 6. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийн тайлбар.....	9
Хүснэгт 7. Тэсэлгээний үед дагаж мөрдөх аюулгүйн зайн хэмжээ.....	10
Хүснэгт 8. Усны нөөцөд үзүүлэх нөлөөллийн тайлбар.....	10
Хүснэгт 9. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийн тайлбар.....	11
Хүснэгт 10. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийн тайлбар.....	11
Хүснэгт 11. Шимт хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийн тайлбар.....	11
Хүснэгт 12. Нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	12
Хүснэгт 13. Агаар мандалд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах төлөвлөгөө.....	13
Хүснэгт 14. Нөхөн сэргээлтийн зардал.....	17
Хүснэгт 15. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний зардал.....	17
Хүснэгт 16. Төслийн явцад хэрэгжүүлэх түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө.....	18
Хүснэгт 17. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	18
Хүснэгт 18. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал.....	19
Хүснэгт 19. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал.....	22
Хүснэгт 20. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	23
Хүснэгт 21. БОМТ-ний хэрэгжилтийн талаар нөлөөлөлд өртөгч оршин суугчид оролцогч талуудад тайлагнах хуваарь.....	24
Хүснэгт 22. БОМТ-ийн нэгдсэн зардал.....	24

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршил.....	3
Зураг 2. Уурхайн харагдах байдал.....	3
Зураг 3. Ашиглалтын эхний жилийн төлөвлөлт.....	5
Зураг 4. Уурхайн 10 дахь жилийн төлөвлөлт.....	6
Зураг 5. Одоо ашиглаж байгаа ИТА нарын амрах болон захиргааны байрын харагдах байдал.....	7
Зураг 6. Одоо ашиглаж байгаа операторуудын амрах байр.....	8
Зураг 7. Одоо ашиглаж байгаа уурхайн гал тогоо, хоолны заал, спорт тоглоомын төв.....	8
Зураг 8. Ажиллагсдын усанд орох газар.....	8
Зураг 9. Ажиллагсдын амрах талбай, ногоон байгууламж.....	8
Зураг 10. Уурхайн тоосжилтын тархах хүрээ.....	10

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч:

“ТЭВХЭН” ХХК

УБД: 9011064132, РД: 2063158

Төслийн нэр:

“Баян шанд шохойн чулууны ордыг ил аргаар олборлох” төсөл

Төслийн зорилго:


Уул уурхайн үйлдвэрлэл хөгжүүлж шохойн чулуу олборлох

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-017063

Төслийн талбайн байршил: MV-017063 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 22.11 га талбай бүхий Баян шанд шохойн чулууны орд нь Төв аймгийн Баян сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 110 км, Зуунмод хотоос зүүн урагш 90км, Баян сумын төвөөс зүүн урагш 5.1 км зайд байрлана.

Хүснэгт 1. Төслийн талбайн координат цэг

№	Уртраг	Өргөрөг
1	107°35'38.45"E	47°11'51.72"N
2	107°35'21.45"E	47°11'51.72"N
3	107°35'21.45"E	47°12'11.73"N
4	107°35' 38.45"E	47°12'11.73"N



Зураг 1. Төслийн талбайн байршил



Зураг 2. Уурхайн харагдах байдал

1.2. Төслийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл

Баян шанд шохойн чулууны орд нь 2012 оны 06-р сарын 08-ны өдөр MV-017063 дугаар бүхий ашиглалтын тусгай зөвшөөрлийг авч байсан.

1.3. Уурхайн хүчин чадал

Төлөвлөж буй ил уурхайн хүрэн дэх үйлдвэрлэлийн нөөцийн хэмжээ нь 8514.08 мян.тн, хүдрийн биетийн дундаж зузаан ойролцоогоор 98 м байна. ордын нөөц их, олборлох шохойн чулууны хэмжээ бага учир төлөвлөлтийн нийт хугацаа нь 72 жил болж байна. Иймд уурхайн төлөвлөлтийг уурхайн ашиглалтын 10-н жилийн төлөвлөлтийг жил тус багцлан тооцоолсон байна. Ордын нөөцийг бодохдоо шохойн чулууны агуулгыг нийт нөөцийн хэсэгшлүүдийн хэмжээнд дундажлан гаргасан байдаг бөгөөд үйлдвэрлэлийн нөөц дэх шохойн чулууны агуулга нь 51.93% байх тооцоо гарсан.

Хүснэгт 2. Олборлолтын хүчин чадал

Ашиглалтын жил	Олборлолтын хүчин чадал /тн/	CaO агуулга, %
1	100000	51.93
2	100000	51.93
3	100000	51.93
4	100000	51.93
5	100000	51.93
6	100000	51.93
7	100000	51.93
8	100000	51.93
9	100000	51.93
10	100000	51.93

Хөрс хуулалтын хүчин чадал: Баян шандын шохойн чулууны биет нь зарим хэсэгтээ гадаргад ил гарсан гарштай бөгөөд газрын гадаргатай маш ойр орших учир хучаас хөрсний зузаан маш бага юм. Харин ордын бодитой В нөөцийн хилийг хэвтээ тэнхлэгтэй перпендикуляр байрлалтайгаар эгц босоо холболтоор тооцоолсон тул уурхайн хажуугийн бүтцээс хамааран тодорхой хэмжээний хөрс нэмэгдэж тооцоологдсон болно.

Уурхайн ашиглалтын явцад ил уурхайгаас 76.2 мян.м³ хөрс хуулалтын ажил хийгдэхээр төлөвлөгдөж байна. Тус ордын Уурхайн эхний 10 жилүүдэд хуулах хөрсний хэмжээ харьцангуй бага байхаар тооцоо гарсан. Өмнө онуудад ашиглалт явуулж байсан уурхайг үргэлжлүүлэн тэлж олборлохоор 10 жилийн төлөвлөлтийг хийсэн тул хуулах хөрсний хэмжээ маш бага байхаар байна. Уурхайн жил бүрийн хөрс хуулалтын хэмжээг доор үзүүлэв.

Хүснэгт 3. Ил уурхайн хөрс хуулалтын хүчин чадал

Ашиглалтын жил	Хөрс хуулалтын хэмжээ, м ³
1	4520
2	4399.2
3	1250
4	3931.1
5	2840
6-10	6839.4
11-85	52443.47
Нийт	76223.17

Ил уурхайн хүрээнд хөрс хуулалтын дундаж коэффициент 0.009 м³/тн байгаа бөгөөд ашигт малтмалын геологийн тогтоц, олборлолтын хүчин чадал зэргээс хамааран хөрс хуулалт уурхайн ашиглалтын жилүүдэд харьцангуй бага байхаар харагдаж байна.

Хүснэгт 4. Ил уурхайн хөрс хуулалтын итгэлцүүр (Ашиглалтын жил бүрээр)

Ашиглалтын жил	Хөрс хуулалтын хэмжээ, м ³	Хүдэр олборлолтын хэмжээ, тн	Хөрс хуулалтын итгэлцүүр м ³ /тн
1	4520	100000	0.045
2	4399.2	100000	0.044
3	1250	100000	0.0125
4	3931.1	100000	0.04
5	2840	100000	0.028
6-10	6839.4	500000	0.014
11-85	52443.7	7514084.7	0.007
Нийт	76223.17	8514083.7	0.009

1.4. Уурхайн ажиллах горим

Уурхайн үйл ажиллагаа нь шохойн чулуу нийлүүлэх цементийн үйлдвэрийн ажиллах

горимтой уялдан ажиллах шаардлагатай бөгөөд уг цементийн үйлдвэр нь өвлийн улиралд ажилладаггүй бөгөөд 4 сарын 15-аас 11- сарын 01 хүртэл ажилладаг байна. Иймд Тус орд нь 3-р сарын 1-ээс 10 сарын 15 хүртэл ажиллах бөгөөд энэ хугацаанд хамаарах Монгол улсын хууль тогтоомжуудад заасан олон нийтээр амрах баяр амралтын хоногууд болон цаг агаарын улмаас саатах, зэрэг хүчин зүйлүүдийг харгалзан үзэж уурхайг 216 хоног ажиллана гэж тооцсон.


Уурхай нь үндсэн горимдоо 216 хоног ажиллах ба хоногт 1 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна.

1.5. Уурхайн одоогийн байдал


Баян шандын шохойн чулууны орд байрлаж буй талбайн гадаргуу нь зүүн хойноосоо баруун урагш намсан тогтоцтой бөгөөд тус ордыг 2013 оноос эхлэн В-1 хэсэгшлийн зүүн хойноос эхлэн ашиглалт явуулж байсан ба тус ашиглалт явуулж байсан талбайгаас үргэлжлүүлэн уулын ажлыг хийхээр төслийн төлөвлөлтийг хийж гүйцэтгэв. Тус хэсгийн хөрсийг хуулж уурхайн баруун урд гадаад овоолго үүсгэн хураасан байгаа ба төслийн эхний 10 жилийн хугацаанд ашиглалтын чиглэл нь баруун болон гүн рүүгээ тэлэх тул уурхайн хажуугийн налуугаас хамааран орох хөрсний хэмжээ маш бага байх юм. Уг олборлолтын ажлыг БНСУ-д үйлдвэрлэсэн Doosan 300 LC экскаватор болон 25 тн даацтай Howo 25 маркийн автосамосвалын хослолоор хийж гүйцэтгэнэ.

2013 оноос ашиглалт явуулж байх хугацаанд тус ордын талбайд шохой шатаах үйлдвэр, ажилчдын амрах байр, шохойн чулууг бутлан ангилах талбай, автопүү зэрэг барилга байгууламжуудыг барьж байгуулсан байгаа юм.

Баян шандын шохойн чулууны ил уурхай нь нөөцийн В-I хэсэгшлийн зүүн хойд захаас эхлэн ашиглалт явагдаж байсан бөгөөд уулын ажлын чиглэл нь зүүн болон зүүн урагш чигийн ахилттайгаар явахаар төлөвлөсөн. Уурхайн нөөц их тул эхний 10 жилийн уулын ажил нь нөөцийн В-I болон В-II хэсэгшлүүд дээр явагдахаар төлөвлөгдсөн. Эхний жилд нийт 4.52 мян.м3 хөрс хуулалтын ажил хийгдэж 100 мян.тн шохойн чулуу олборлох бөгөөд 2 дахь жилд 4.4 мян.м3 хөрс хуулж 100 мян.тн шохойн чулуу олборлоно. Эхний болон 2 дахь жилийн уурхайн гүн дундажаар 20 м байна



Зураг 3. Ашиглалтын эхний жилийн төлөвлөлт



Зураг 4. Уурхайн 10 дахь жилийн төлөвлөлт

1.6. Олборлолтын технологи

Баян шандын ил уурхайн шохойн чулууны хатуулаг нь 9-11 учир өрөмдлөг тэсэлгээгээр сийрэгжүүлж экскаватораар ухаж ачин автосамосвалаар тээвэрлэж уурхайн гарц траншейн амнаас 0.1 км–т байрлах шохойн чулууны нөөцийн түр овоолго хүртэл тээвэрлэнэ. Олборлолтын үед шохойн чулууны бохирдлын хэмжээг бага байлгах үүднээс хүдрийн биет болон хөрсний зааг хэсгийн хүдрийг ачих үедээ хаяхаар тооцсон. Олборлолтын ажлын доголын өндөр нь 5м, ажлын бус доголын өндрийг 10м, ажлын доголын хажуугийн чулуулгийн физик механик шинж чанараас нь хамааруулан 55 градус байна.

1.7. Уурхайн дотоод тээвэр

Уурхайн ашиглалтын эхний 10 жилд гарах хөрсийг төлөвлөж буй ил уурхайн эцсийн хүрээний гадна байрлах гадаад овоолго хүртэл тээвэрлэх ба харин ашиглалтын сүүлийн жилүүдэд уурхайн доторх ашиглагдсан хоосон орон зайд овоолго үүсгэх боломжтой. Харин шохойн чулууг уурхайн зүүн урд хэсэгт байрлах бутлан ангилах хэсгийн түр овоолго хүртэл автосамосвалаар тээвэрлэнэ гэж төлөвлөсөн.

Экскаваторын мөчлөгийн хугацаа харьцангуй бага учир 8 удаа утгалт хийхээр бодож тооцоход 23.6-24.8 тн гэсэн утга гарч буй тул 20 тн даацтай, 14 м³ тэвшний багтаамжтай Howo маркийн автосамосвалыг шууд ашиглах боломжтой харагдаж байна. Уг автосамосвалын техникийн үзүүлэлтийг дараа хүснэгтэд үзүүлээ.

Хүснэгт 5. Howo 25 автосамосвалын техникийн үзүүлэлт

Автосамосвалын төрөл	Howo
Даац, тн	25
Масс, тн	16
Тэвшний багтаамж, м³	14
Хурд, км/ц	70
Эргэлтийн радиус, м	10
Хөдөлгүүр	WP615,43i
Хөдөлгүүрийн чадал, м.х	215
Дугуйн томъёо	8x2
Овор хэмжээ , урт– өргөн–өндөр, мм	7254x2598x3264



Уурхайд нийт 20 тн даацтай 1-н ширхэг автосамосвал ажиллахаар төлөвлөсөн байна.

1.8. Уурхайн дэд бүтэц, түүхий эд

Уурхайн засвар механикийн цех

Уурхайн засвар, техникийн үйлчилгээний дэд бүтэц нь уул–тээврийн машин, тоног төхөөрөмж, бусад туслах тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор техникийн үйлчилгээ, урсгал засвар, дунд засвар хийх, техникийн үйлчилгээ, засварын ажилд

шаардлагатай аливаа материал, сэлбэг хэрэгсэл, түлш, тос, тосолгооны материал зэргийг хүлээн авах, хадгалах, тээвэрлэх, тавьж олгох зориулалттайгаар байгуулагдана.

Уурхайн засварын цех нь машин тоног төхөөрөмжийн техникийн үйлчилгээ, урсгал засвар, дунд засвар, түргэн элэгдэх эд ангиудыг солих, агрегатын засварыг хийх зориулалттай. Энд гагнуурын аппарат, ирлэх, харуулах, өнгөлөх, хайчлах зэрэг олон үйлдэлтэй суурь машинууд, гүүрэн кран, тэргэнцрүүд зэрэг тоноглолууд зайлшгүй шаардлагатай.

Засварын газрын шал нь бетон бөгөөд хатахдаа резин болдог будгаар бүрэн будаж, засвар механикийн цехийн доторх дугуй засварын хэсэг, гагнуурын хэсэг, угаалга, тосолгооны хэсэг зэргийг тусгаарласан шар будгаар хүрээ гаргасан байна. Гагнуурын хэсэг, угаалга тосолгооны хэсэг нь мөн тусгаарласан төмөр хашлагатай байна. Эдгээр нь засварын үед тос тослох материалын асгаралтаас үүсэлтэйгээр газрын хөрс шууд бохирдохоос сэргийлэхийн зэрэгцээ аюулгүй ажиллагааг хангах нэг хүчин зүйл болно.

Мөн шингэн түлш, шингэрүүлсэн хий, тос, тосолгооны материал, бусад шатамхай бодисын буруу хадгалалт, ашиглалтын горимын зөрчлөөс гал гарч болзошгүй тул гал унтраах хэрэгслээр бүрэн тоноглогдсон байна. Мөн гал гарсан тохиолдолд ажиллагсад тухайн байрнаас гарах гарцын тоо 2-аас доошгүй байхаар зохион байгуулагдаж ажилтнууд цугларах цэгт хүрнэ. Үүнийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтаар эзэмшүүлсэн байна.

Машин, тоног төхөөрөмжийн засварын ажлын зарим хэсгийг тэдгээрийн ажлын байранд хийж гүйцэтгэхтэй холбогдуулан уурхайн засварын домкратууд, кран, өрмийн ба өнгөлөх, тэгшлэх суурь машинууд, кислород, ацителин бүхий баллонууд, цахилгаан дөш, трансформатор зэргээр тоноглогдоно.

Уурхайн засвар механикийн цех нь уурхайн ашиглалтын нийт хугацаанд ашиглагдах тул 20x14 м харьцаа бүхий сайн чанарын сэндвичэн барилга байхаар төлөвлөсөн. Засвар механикийн цехийн таазны өндөр нь тухайн уурхайд ажиллаж буй автосвал тэвшээ бүрэн өргөх, экскаватор сумаа өргөхөд ямар нэгэн саад болохооргүй өндөртэй байна.

Харуулын пост, хашаа

Харуул хамгаалалт, шалган нэвтрүүлэх байр нь гаднаас уурхайн бүсэд нэвтэрч байгаа ажиллагсад болон бусад хүмүүсийн бичиг баримтыг шалгах байр байна. Уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрлийн хил, эдэлбэр талбайн эргэн тойронд гадны хүн, мал амьтан нэвтрэхээс сэргийлсэн төмөр хашааг татаж хашаалсан байна.

Уурхайн ажиллагсдын байр, хоолны газар

Уурхайн тосгон нь нийт ажилчдын амрах байр, оффис болон хоол цайны газар спорт тоглоомын байр, ариун цэвэр угаалгын байр зэргээс бүрдэнэ. Ажилчдын амрах болон оффис мөн цайны газар болон ариун цэврийн байр зэргийг “Тэвхэн” ХХКомпани 2013 онд барьж байгуулсан байна.



Зураг 5. Одоо ашиглаж байгаа ИТА нарын амрах болон захиргааны байрын харагдах байдал



Зураг 6. Одоо ашиглаж байгаа операторуудын амрах байр



Зураг 7. Одоо ашиглаж байгаа уурхайн гал тогоо, хоолны заал, спорт тоглоомын төв



Зураг 8. Ажиллагсдын усанд орох газар



Зураг 9. Ажиллагсдын амрах талбай, ногоон байгууламж



2. ТӨСЛИЙН БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Хүснэгт 6. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийн тайлбар

№	Төслийн үйл ажиллагаа	Байгаль орчны элементүүдэд үзүүлэх нөлөөллийн тайлбар
1	Шимт хөрс хуулалт, тээвэрлэх	Хөрс хуулалтыг бульдозероор гүйцэтгэх бөгөөд бульдозерийн дизель хөдөлгүүрээс ялгарах CO, CO2, Nox, SO4 болон бусад бохирдуулагч бодисын агаар дахь дисперсээр агаарын чанарт өөрчлөлт орж болно. Мөн салхитай хуурай үед хөрс хуулалтын ажил явуулах үед агаарт тоосонцор дэгдэнэ.
2	Шимт хөрс хадгалах	Шимт хөрс хадгалалт буюу шимт хөрсний овоолго нь бүрхэвч ургамлаар хучигдах учир агаар орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй гэж үзэв.
3	Өрөмдлөг, тэсэлгээ	Тэсэлгээний үед их хэмжээний тоосжилт үүснэ. Энэ нь агаар орчинд сөрөг нөлөө үзүүлнэ.
4	Шохой олборлолт	Хүдэр олборлолтыг экскаватораар гүйцэтгэх бөгөөд экскаваторын дизель хөдөлгүүрээс ялгарах CO, CO2, Nox, SO4 болон бусад бохирдуулагч бодисын агаар дахь дисперсээр агаарын чанарт өөрчлөлт орж болно. Мөн салхитай хуурай үед хүдэр олборлолтын ажил явуулах нь агаарт тоосонцор дэгдэх нөхцөлтэй.
5	Уурхайлалтаас үүссэн ухаш	Ухаш нь агаарын чанарын бохирдуулагч эзэлхүүний эх үүсвэр болно.
6	Шохой шатаах зуух	Шохой шатаах үед үүсэх утаа, тоосжилт зэрэг нь агаар мандалд сөрөг нөлөөлөл үзүүлнэ.
7	Шохой тээвэрлэх	Тээвэрлэлтийн үед автомашины нөлөөгөөр агаарт тоосжилт үүснэ. Мөн хүдрийг автосамосвалаар тээвэрлэх ба дизель хөдөлгүүрээс ялгарах CO, CO2, Nox, SO4 болон бусад бохирдуулагч бодисын агаар дахь дисперсээр агаарын чанарт өөрчлөлт орж болно.
8	Ахуйн хаягдал	Удаан хадгалсан тохиолдолд агаарт үнэрийн бохирдол үүсч болно.

Тэсэлгээний үед үүсэх тоосжилтын хэмжээ

Тус уурхай жилд 28.7 тн тэсрэх бодис хэрэглэх бөгөөд ойролцоогоор нэг удаа тэсэлгээ хийхэд 92 ширхэг шруп өрөмдөж 1 удаагийн тэсэлгээнд 3.5 тн тэсрэх бодис хэрэглэн дунджаар 79 мян.м³ уулын цул суллана. Жилд 8 удаа буюу сард нэг удаа тэсэлгээ хийнэ гэж тооцвол нэг удаагийн тэсэлгээний ажлын үед үүсч болох хорт хийтэй тоосорхог үүлний эзэлхүүнийг нэг удаад хэрэглэгдэх тэсрэх бодисын хэмжээ $A < 3.0$ тн үед 5555.24м^3 .

Уурхай орчимд тоосорхог үүлтэй хаягдаж буй бохирдуулагч бодисын нийт хэмжээ (тн)-г $P_0 = \frac{P}{1000} \left(1 - \frac{P}{1000} \right)$ томъёогоор олно.


Энд: k -бохирдуулагч бодисын гравитацийн суулт (уналт)-ыг тооцсон коэффициент буюу тоосонд $k=0.168$, хийд $k=1.0$ гэж авна.

q - 1.0 тн бодис тэсрэхэд ялгарах бохирдуулагч бодисын хэмжээ (тн/тн) ба үүнийг тэсрэх бодисын хувийн зарцуулалт 0.93-аас хамааруулж авбал $q=0.162$ тн/тн ба ялгарах CO хийн хувьд $q_x=0.001$ тн/тн гэж авна.

Тоос: 0.002тн

Хий: 0.000026 тн

Энэ хийн 50 орчим хувь нь CO хий байдаг учир нүүрсхүчлийн дутуу исэл 0.03 кг үүсэхээр байна. Уурхайн тэсэлгээний үед үүсэх тоос нь салхины үйлчлэлээр туугдаж ихэвчлэн зүүн ба зүүн урагш нүүж газрын гадарга дээр унаж хөрс ургамлыг бохирдуулна.



Зураг 10. Уурхайн тоосжилтын тархах хүрээ

Тэсэлгээний үед үүсэх газрын чичирхийллийн аюулгүйн зай:

Бөөн цэнэгээр нэг удаа тэсэлгээ хийхэд газрын хөрсний доргилт барилга байгууламжид аюулгүй байх зайн тооцоо

$$R_{\text{цаз}} = K_x \cdot K_6 \cdot \sqrt[3]{Q} = 8 \cdot 1 \cdot 5.17 = 41.36 \text{ м}$$

K_x - Байшин барилгын суурин дахь хөрсний хамаарлын итгэлцүүр

/Ан цавархаг өгөршсөн хөрсөнд $R_r = 8$ -аар авна/

K_6 - Барилгын хийцээс хамаарах итгэлцүүр /металл, төмөр, бетон хийцтэй бол $K_6 = 1$ /

Q - Нэг агшинд тэслэгдэх цэнэгийн хэмжээ, кг 138 кг

Агаарын цохих долгионоос байшин барилгад нөлөөлөх аюулгүйн зай:

$$R_{\text{цаз}} = K_B \cdot \sqrt[3]{Q} = 12 \cdot 5.17 = 62.04 \text{ м}$$

K_B - Тэсрэлтийн тавцангаас байшин барилгын зай байршил мөн тухайн объектын барилгын хийцийн зэрэглэл гэж хамааруулж сонгож авна. $K_B = 12$

Хүснэгт 7. Тэсэлгээний үед дагаж мөрдөх аюулгүйн зайн хэмжээ

д/д	Үзүүлэлтүүд	Барилга байгууламжид	Хүнд	Тоног төхөөрөмжид
1	Тэсэлгээгээр чулуулгийн шидэгдэх аюулгүйн зай, м	–	233	150
2	Тэсэлгээний үеийн чичирхийллийн аюулгүйн зай, м	42	–	–
3	Агаарын долгионы үйлчлэх аюулгүйн зай, м	63	126	–

Хүснэгт 8. Усны нөөцөд үзүүлэх нөлөөллийн тайлбар

№	Төслийн үйл ажиллагаа	Байгаль орчны элементүүдэд үзүүлэх нөлөөллийн тайлбар
1	Шимт хөрс хуулалт, тээвэрлэх	Нөөцөд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй
2	Шимт хөрс хадгалах	Нөөцөд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй
3	Тэсэлгээ	Тэсэлгээний үед гүний усны нөөцөд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.
4	Шохой олборлолт	Хүдэр олборлолтын үед шүүрэлт явагдсан тохиолдолд усны нөөцөд нөлөөлөл үзүүлж болзошгүй юм.
5	Уурхайлалтаас үүссэн ухаш	Ухаш үүсэх нь ул хөрсний ус гадаргад ил гарах нөхцлийг хангаж байгаа гэдэг утгаараа газрын доорхи усны нөөцөд нөлөөлнө.
6	Шохой шатаах зуух	Шатаах зуухны технологит ус ашиглахгүй тул усны нөөцөд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.
7	Шохой тээвэрлэх	Нөөцөд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй
8	Ахуйн хаягдал	Ахуйн хатуу хог хаягдлыг зориулалтын битүүмжилсэн саванд хаяхгүй тохиолдолд гадаргын усанд бохирдол үзүүлж болно.

Хүснэгт 9. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийн тайлбар

№	Төслийн үйл ажиллагаа	Байгаль орчны элементүүдэд үзүүлэх нөлөөллийн тайлбар
1	Шимт хөрс хуулалт, тээвэрлэх	Хөрс хуулалт нь ургамлан бүрхэвчид шууд нөлөөлөл үзүүлнэ. Тээвэрлэлт нь шууд болон дам нөлөөлөл үзүүлж болзошгүй
2	Шимт хөрс хадгалах	Шимт хөрсний овоолгод ургамлан бүрхэвч дарагдана.
3	Тэсэлгээ	Тэсэлгээний хийгдэж буй газрын ургамлан нөмрөг устаж үгүй болно. Мөн тэсэлгээнээс үүссэн тоосжилт ойр орчмын ургамлан нөмрөгт сөрөг нөлөө үзүүлнэ.
4	Шохой олборлолт	Хүдэр олборлолтоос үүсэх тоосонцорын тархалт нь ургамлан бүрхэвчид дам нөлөөлөл үзүүлэх ба олборлолтонд өртөж буй талбайн ургамлан нөмрөг устаж үгүй болно.
5	Уурхайлалтаас үүссэн ухаш	Агаарын бохирдлын эх үүсвэр болж байгаа учир ургамлан бүрхэвчид дам нөлөөлөл үзүүлнэ.
6	Шатаах зуух	Шатаах зуухны яндангаас гарах угаа, тоосжилт зэрэг нь ургамлын ургах орчин, ургацад сөрөг нөлөөлөл үзүүлнэ.
7	Шохой тээвэрлэх	Тээвэрлэлт нь шууд болон дам нөлөөлөл үзүүлнэ. Тоосжилт үүсгэнэ. Мөн тээвэрлэлтийн автозам ургамлан бүрхэвчгүй болно.
8	Ахуйн хаягдал	Ахуйн хаягдал хадгалах сав нь ургамлан бүрхэвчийг доройтуулна. Мөн хог хаягдлыг ил задгай хаяснаар зэрлэг ургамал элбэгших зэрэг нөлөөлөл үүсч болзошгүй.
9	Уурхайн кемп	Барилга байгууламжуудад ургамлан бүрхэвч дарагдана. Мөн ургамлан бүрхэвч бохирдож болзошгүй юм.
10	Засварын талбай	Талбайд ургамлан бүрхэвч устана.

Хүснэгт 10. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийн тайлбар

№	Төслийн үйл ажиллагаа	Байгаль орчны элементүүдэд үзүүлэх нөлөөллийн тайлбар
1	Шимт хөрс хуулалт, тээвэрлэх	Хуулагдаж буй шимт хөрсөнд амьдарч байсан хөрсний бичил организ, нүхэнд амьдардаг амьтдын үүр эвдрэх, шимт хөрс хуулалтын үеийн бульдозерын дуу чимээ, газар чичирхийлэл, үүсэх тоосжилт зэрэг нь амьтдын шилжилт хөдөлгөөн, амьдрах орчинд сөрөг нөлөөлөл үзүүлнэ.
2	Шимт хөрс хадгалах	Сөрөг нөлөөлөл нь дээрхтэй ерөнхийдөө адил. Шимт хөрсний овоолгод зарим амьтдын орон байр болох эерэг нөлөөлөл байж болно.
3	Хөрсний гадаад овоолго	Гадаад овоолго байгуулах үеийн дуу чимээ, тоосжилт зэрэг нь амьтдын шилжилт хөдөлгөөн, амьдрах орчинд сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Мөн жижиг амьтдын амьдрах орчныг сүйтгэх сөрөг нөлөөтэй.
4	Шохой олборлолт	Хүдэр олборлолтын үеийн дуу чимээ, тоосжилт зэрэг нь амьтдын шилжилт хөдөлгөөн, амьдрах орчинд сөрөг нөлөөлөл үзүүлнэ.
5	Уурхайлалтаас үүссэн ухаш	Мөн хөрс хуулалт, элс олборлолтоос үүсэх ухшинд өвлийн улиралд том хөхтөн амьтад, мал унаж бэртэх аюултай юм.
6	Шатаах зуух	Шатаах зуухны яндангаас гарах угаа нь ойр орчимд амьдрах амьтдын идэш тэжээлийн хомсдол үүсгэх, нүүдэллэх газар нутгийн хэмжээг багасгах зэрэг сөрөг нөлөөлөл үүсгэж болзошгүй.
7	Шохой тээвэрлэх	Хүдэр тээвэрлэлтийн үеийн дуу чимээ, тоосжилт зэрэг нь амьтдын шилжилт хөдөлгөөн, амьдрах орчинд сөрөг нөлөөлөл үзүүлнэ.
8	Ахуйн хаягдал	Ахуйн хог хаягдлын ил задгай хаяснаас амьтад идэж хордох, орооцолдож үхэх зэрэг сөрөг нөлөөлөл үүсэж болзошгүй.
9	Уурхайн кемп	Барилга байгууламжид дарагдах хөрсний бичил организм устаж болзошгүй. Мөн кемпийн дуу чимээнээс амьтад үргэж дайжих, амьдрах орчин багасах сөрөг нөлөөтэй.
10	Засварын талбай	Дээрхитэй адил

Хүснэгт 11. Шимт хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийн тайлбар

№	Төслийн үйл ажиллагаа	Байгаль орчны элементүүдэд үзүүлэх нөлөөллийн тайлбар
1	Шимт хөрс хуулалт, тээвэрлэх	0.2-0.3м-с ихгүй зузаантай шимт хөрс хуулагдана. Хөрс тээвэрлэлтийн үед шимт хөрс нөлөөлөлд өртөнө.
2	Шимт хөрс хадгалах	Шимт хөрс хадгалах үед тухайн газрын шимт хөрсний ялзмагийн хэмжээ тэр хэмжээгээр нэмэгдэх сайн талтай юм. Харин шимт хөрсийг стандартын дагуу суурь судалгаанд үндэслэн хуулаагүй үед сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй юм.
3	Хөрсний гадаад овоолго	Овоолгон доор дарагдаж буй шимт хөрсөнд нөлөөлөл үүснэ.
4	шохой олборлолт	Хүдэр олборлолтын үеийн тоосжилтоор дам нөлөөлөлд өртөнө.
5	Уурхайлалтаас үүссэн ухаш	Агаарын бохирдлын эх үүсвэр болох учир шимт хөрсний чанарт дам нөлөөлөл үзүүлнэ.

6	Шатаах зуух	Шатаах зуух суурилуулсан суурин хэсгийн хөрсөн бүрхэвч дарагдаж шимт байдлаа алдах сөрөг нөлөөлөлтэй.
7	Шохой тээвэрлэх	Тээвэрлэлтийн үеийн шороон замд шууд, шороон замаас үүсэх тоосжилтоор дам нөлөөлөлд орно.
8	Ахуйн хаягдал	Ахуйн хаягдлаар хөрс биологийн бохирдолд орно.
9	Шатах тослох материалын хаягдал	Шимт хөрс хүнд металаар бохирдоно.
10	Засварын талбай	Дээрхитэй адил

Хүснэгт 12. Нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл

№	Төслийн үйл ажиллагаа	Байгаль орчны элементүүдэд үзүүлэх нөлөөллийн тайлбар
1	Шимт хөрс хуулалт, тээвэрлэх	Үүсэх тоосонцор нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж болно. Мөн хөрс хуулах үед техник тоног төхөөрөмжтэй харьцах аюулгүй ажиллагааны дүрэм зөрчихтэй холбоотой гэмтэх тохиолдол гарч болно.
2	Шимт хөрс хадгалах	Нөлөөлөл үзүүлэхгүй
3	Хөрсний гадаад овоолго	Гадаад овоолгоос үүсэх тоосонцор нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй юм.
4	Шохой олборлолт	Үүсэх тоосонцор нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж болно.
5	Ухаш	Ухашинд ажилчид болон ойр орчмын ард иргэд унаж бэртэх аюултай.
6	Шатаах зуух	Шатаах зуухны яндангаас гарах утаа нь орон нутгийн иргэд болон ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй.
7	Шохой тээвэрлэх	Үүсэх тоосонцор нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж болно.
8	Ахуйн хаягдал	Ахуйн хаягдлын ялзарлаас үүсэх үнэрийн бохирдол болон түүнээс ялгарах хорт бодис нь хүний эрүүл мэндэд нөлөөл үзүүлж болзошгүй юм.
9	Шатах тослох материал	Техник тоног төхөөрөмжтэй харьцах аюулгүй ажиллагааны дүрэм зөрчихтэй холбоотой гэмтэх тохиолдол гарч болно.
10	Засварын талбай	Техник тоног төхөөрөмжтэй харьцах аюулгүй ажиллагааны дүрэм зөрчихтэй холбоотой гэмтэх тохиолдол гарч болно.

3. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, БОННҮнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Мөн төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага, зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар авах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгасан байх шаардлагатай.

Төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг тухайн төслийн хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь үйл ажиллагааныхаа зардалд багтаан төлөвлөж зарцуулах.

Иймд “Тэвхэн” ХХК нь байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулах зорилгын хүрээнд 2019 оноос байгаль орчны зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий “Солонгон төгөл” ХХК- тай хамтран ажиллаж 2024 оны БОМТөлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах зорилготой.

4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 13. Агаар мандалд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян/төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян/төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Агаарын чанар	Уурхайн олборлолтын үе шатанд тоосжилт ихээр үүсэх үед усалгаа хийх	Төслийн талбайн ойр орчимд	Хоног	6.0	110	660.0	Дулааны улиралд	БОС-ын 1995 оны 153тоот тушаал
		Усалгааг өөрийн мананжуулах төхөөрөмжийг ашиглан гүйцэтгэх	Тоосжилт үүсэх хэсэгт	ширхэг	-	1	-	Дулааны улиралд	-
		Тээвэрлэлтийн үед гарах тоос шороог багасгах үүднээс хаягдал чулуугаар уурхайн дотоод болон гадаад замуудын хайрга чулуун хучилтыг нөхөх, нэмэх	Тээвэрлэлтийн зам	м	-	700	ҮА зардал	2023 онд	-
		Хүдэр болон шороо тээвэрлэлтийн үед автомашины тэвшний бүтээлэг ашиглах, ашиглалтанд хяналт тавих	Тээвэрлэлтийн зам, уурхайн ойр орчим	ширхэг	-	-	-	Ашиглагдаж байгаа	
		Уурхайн карьерт орж гарах машин, ачилт буулгалтын цаг хугацаа, хоорондын зайг тоосны сарнилтай уялдуулан оновчтой байлгах тооцоог хийж мөрдөж ажиллах	Төслийн талбайн ойр орчимд	-	-	-	-	Үйл ажиллагааны турш	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008
		Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, хаалга цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг хийж агаарыг цэвэршүүлэх төхөөрөмж хэрэгслийг бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах	Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах автомашин	-	-	-	ҮА зардал	Жилд нэг удаа	-
		Уурхайн машин механизмуудын янданд шүүлтүүр тавих, ашиглалт, бүрэн бүтэн байдалд хяналт тавих.	Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах автомашин	-	-	-	ҮА зардал	Жилд нэг удаа	Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003 Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003
		Хүнд машин механизмын утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах, үзлэг шалгалтыг хийх засвар үйлчилгээг тогтмол хийх	Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах автомашин	Машин	ХХАА-ны зардалд	5	-	Жилд нэг удаа	MNS(ISO)13688:2000 MNS3306:1991 MNS5620:2006 MNS5623:2006 MNS5388:2004 MNS5389:2004
Нийт							660.0		
2	Гад арг ын ба	Ахуйн бохир усыг цэвэршүүлэн ногоон байгууламжийн усалгаанд ашиглах,	-	-	-	-	-	Үйл ажиллагааны турш	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян/төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян/төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг	
		Өөрийн гүний худгийн усны түвшинг хэмжиж тэмдэглэл хөтлөх /түвшин хэмжигч/	Гүний худаг	ширхэг	-	1	350.0		MNS 4288:1995 /ЗГ-ын 2013 оны 326 дүгээр тогтоолын хавсралт –Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/	
		Усалгааны ашиглах усны хэрэглээг бага байлгах үүднээс барьцалдуулах бодис ашиглах	Олборлолтын хэсэг, зам	-	-	-	450.0			
		Ахуйн усны хэрэглээг тооцох Хэмнэлттэй зарцуулах техник технологи ашиглах	-			Баяншандын орд нь Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт хамаарах ба 1 м ³ гадаргын усны ЭЭЗ үнэлгээ 3700 төг байна. Үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглавал 0.6 коэффициентээр/ үйлдвэрлэлийн зориулалтаар хэрэглэх усны үнэлгээ нь 2220 төг/м ³ болох юм.Уул уурхайд энэ үнэлгээний 20%-иар тооцож төлбөр төлнө. 2220*20% = 1776 төг байна.		Үйл ажиллагааны турш		
		Ус ашиглалтын гэрээ байгуулах, ус ашигласны төлбөр төлөх	-		Үйл ажиллагааны турш					
Нийт							800.0			
3	Хөрсөн бүрхэвч	Шимт хөрсний овоолгыг ургамалжуулах, байгалийн аясаар ургамал ургах нөхцлийг бүрдүүлэх	Хөрсөн бүрхэвч	-			300.0	Үйл ажиллагааны турш	MNS 5915:2008	
		ШТМ-ыг стандартын дагуу хадгалж байгаа эсэхд байнгын хяналт тавих	Хөрсөн бүрхэвч	-	-	-	-	Үйл ажиллагааны турш	-	
		Машин механизмын засвар үйлчилгээ хийх талбайн бетон хучилтыг нэмэгдүүлэх	Хөрсөн бүрхэвч			Үйл ажиллагааны зардал			2023 онд	-
		Хөрсний бохирдол үүсэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад байнга анхааруулах	Хөрсөн бүрхэвч	-	-	-	-	-	Үйл ажиллагааны турш	-
		Хөрсний овоолго болон шимт хөрсний овоолгыг төлөвлөгөөний дагуу цэгцтэй хураах	Хөрсөн бүрхэвч	-		Үйл ажиллагааны зардал			Үйл ажиллагааны турш	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга
		Автомашин хурдыг боломжит хэмжээгээр хязгаарлах арга хэмжээ авах	Хөрсөн бүрхэвч	-	-	-	-	-	Үйл ажиллагааны турш	-
		Уурхайн болон бусад үйл ажиллагааны улмаас эвдэрч ургамлан бүрхэвчгүй болсон талбайн хөрсний үржил шимийг	Хөрсөн бүрхэвч	-	-	-	-	-		

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян/төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян/төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
		дэмжих ажлыг хийх							
		Уурхайн ашиглаж дууссан газрыг тэгшилж янзлан шимт хөрсөөр хучин ургамал ургах нөхцлийг бүрдүүлэх	Уурхайн талбай болон ойр орчмын хөрсөн бүрхэвч	-	-	-	ҮА зардал	-	-
Нийт							300.0		
4	Газрын хэвлий	Уурхайн олборлолтыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх	Газрын хэвлий	-	-	-	-	Үйл ажиллагааны турш	ТЭЗҮ
		Үйл ажиллагаанд ач холбогдолгүй газрын хэвлий хөндөхгүй байх	Газрын хэвлий	-	-	-	-	Үйл ажиллагааны турш	-
		Уурхайн ерөнхий төлөвлөлтийг зөв сонгох	Газрын хэвлий	-	-	-	-	Үйл ажиллагааны турш	ТЭЗҮ
5	Ургамлан нөмрөг	Уурхайн зөвшөөрлийн талбай болон түүний ойр орчмын талбайн ашиглалтыг сайжруулах бэлчээр эдэлбэрийг хэвийн хадгалахад сум багийн удирдлагуудтай хамтран ажиллах.	Ургамлан нөмрөг	-	-	-	ОХШХ-ийн зардал	Үйл ажиллагааны турш	-
		Хөрсний нөхөн сэргээлт хийж дууссан талбайн хэсгүүдийг ургамалжуулахад зориулж үр суулгацыг туршиж бэлтгэх ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх	Ургамлан нөмрөг	-	-	-	-	Жил бүр	MNS 5917:2008
		Хөрсний шинж чанар, хөрсний усны түвшинг харгалзан үзэж суулгац, олон наст ургамлын үр цацах замаар ургамалжуулна. Энд үр цацсан нөхцөлд хийсэхээс хамгаалах арга хэмжээг авсан байх, эсвэл үрсэлгээ хийсний дараа суулгац суулгах.	Ургамлан нөмрөг	-	-	Биологийн нөхөн сэргээлт хийх тохиолдолд хамаарна.		-	MNS 5917:2008
		Биологийн нөхөн сэргээлтийг мэргэжлийн хүмүүсийн оролцоотой, тэдний заавар зөвлөмжөөр гүйцэтгэнэ.	Ургамлан нөмрөг	-	-	2024 онд уурхайд нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй ба ногоон байгууламжийн арчилгаа тордлогоны ажлыг гүйцэтгэнэ.		-	MNS 5917:2008
6	Амьтны аймаг	Төв замаас уурхайн орох замд амьтдын гүйдэл тааралдахгүй ба орон нутагтай хамтарч ажиллах ажлын хүрээнд ан амьтдын гүйдэлтэй газарт анхааруулах тэмдэг байрлуулах ажлыг зохион байгуулах.	Амьтны аймаг	Ширхэг	50.0	5	200.0	Үйл ажиллагааны эхний жилд	-

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян/төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян/төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг	
		Уурхайн ан амьтдын тухай тэдгээрийн байршилт, амьтан хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, амьтны ач холбогдлын талаар жилд нэг удаа ажилчдын дунд семинар зохион байгуулж, мэдээлэл өгөх	-	-	-	1	-	Жил болгон тогтмол 1-2 удаа	-	
		Хог хаягдлыг шаардлагын дагуу хадгалж зайлуулах, уурхайгаас гарах усыг мал, амьтанд сөргөөр нөлөөлөхгүй байх арга хэмжээ авч байх, бохир усны шинжилгээг жилд 2 удаа өгч байх.	Амьтны аймаг	-	-	-	-	Жил бүр	-	
		Уурхайн нутаг дэвсгэрт болон өөрийн ажилчдыг ан хийлгэхгүй байх талаар анхааруулж, мөрдлөг болгон ажиллах.	Амьтны аймаг	-	-	-	-	Үйл ажиллагааны турш	-	
		Төслийн үйл ажиллагаатай холбоотой зэрлэг амьтдын хоол тэжээл хомсдох, цөөрөх зэргийг судлах үүднээс мониторинг судалгаа хийлгэх.	Уурхайн ойр орчимд байх амьтад				1200.0 ҮА зардал			
Нийт							200.0			
НИЙТ ДҮН							1960.0			

5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Техникийн болон биологийн нөхөн сэргээлт

